

## Монгол Данжуурын орчуулга сонгодог

### орчуулгын чиг болох нь

Г.Дамбадаржаа /”Цогт цагийн хүрдэн” соёлын төв/

Монгол мэргэдийн оюуны эх ундарга болсон Монгол Ганжуур Данжуур нь гурван сав аймаг, гурван суртгаалын эш онолыг их бага арван ухааны ай савд аймаглан хуваарилж цэгцтэй номлосон буддын мэдлэг ухааны эх сурвалж болохын сацуу орчин цагийн шинжлэх ухааны салбар чиглэлд хамаарах бүхий л утга санааг бүрэн агуулсан их нэвтэрхий толь гэдэгтээ маргах хүн үгүй бизээ. Өөрөөр хэлбэл Ганжуур бол мэдлэг ухааны эш үндэс нь, харин Данжуур нь түүнд тулгуурлан утга санааг тайлсан тайлбар толь юм. Бид Монгол Данжуурын орчуулгын зарчим, ерөнхий хэв маягаас хэдэн зүйл дурдах санаа өвөрлөсөн болно. Гэхдээ 3427 нэр төрлийн ном зохиол багтсан 226 боть бүтээлийг нааш цааш эргүүлж нэг бүрчлэн уншиж судалснаар орчуулга болон түүний утга агуулгын сонгодог хэлбэрийг бүрэн илэрхийлэх нь ойлгомжтой.

Хэдий тийм боловч ачит номын багш, ухаант мэргэд, номын нөхдийн тус дэмээр Монгол Ганжуур Данжуураа хөрвүүлэх ховорхон хувь тохиож өдөр бүр хөрвүүлэх, хянах ажлыг хамтын хүчээр хийсээр даруй 3 жил өнгөрч өдгөө Монгол Ганжуурын 20-иод боть, Данжуурын 100 ботийг бүрэн хөрвүүлж хэвлэх шатандаа явж байна. Олныг үл нуршин өдий хүртэл Монгол Данжуурын орчуулгын талаар олж мэдсэн, тэмдэглэж авсанганц нэг зүйлдээ дулдуйдан их бус дараах хоёрсанааг та бүхэнд толилуулъя.

1. Нэр, томъёо, үгийн гарал үүслийг хадгалалах зарчмыг илүүтэй баримталсан
2. Утгын оноч үгийн баялаг чухалчилсан

**Нэг. Нэр томъёо, үгийн гарал үүслийг хадгалалах зарчмыг илүүтэй баримталсан тухайд**

Монгол Данжуурын орчуулга нь аливаа нэр томъёо болон үгийн гарал язгуурыг илүүтэй хадгалсан нь илэрхий ажиглагдаж байна. Оноосон нэрийг ихэвчлэн санскритаар буулгасан байх боловч зарим үед монголоор орчуулсан байдаг. Жишээ нь:

Язгуурын таван бурханы нэр:

1. Бирозана /Намбарнанзад/
2. Амогасидди /Дондүв/
3. Ачуваяа /Мижодва/
4. Амидива /Одбогмэд/
5. Раднаасамбава /Ринжүн/ хэмээн санскритаар орчуулжээ.

Мөн Занасадва, Базарсадва, Бодьсадва, Махасадва, Хэрүга, Ямандага, Махадива гэх мэтчилэн бурхад, тэнгэрийн нэрсийг санскритаар буулгасан. Энэ нь утга санааг хагас дутуу илэрхийлэхээс зайлсхийж үгийн язгуурыг хадгалан утгыг төгс илэрхийлэх зарчим болно. Жишээлбэл “Зана” хэмээх нь түвдээр “Иши”, монголчилбол “Бэлгэ билиг” буюу “юмсын шинж чанарыг төгс таних ухаан” гэсэн бүрэн утгаараа ойлгогдож байгаа юм. Гэтэл орчин цагт санскрит уг гарвалыг үл хайхран шууд түвд хэлний “Иши” гэсэн үгнээс “Билиг” хэмээн монголчилсон ажиглагддаг. Энэ нь утга санааг гүйцэт илэрхийлж чадахгүйгээр үл барам гажуудуулах талтай.

Гэхдээ дан санскрит нэр томъёог голчилсон уу гэвэл үгүй. Тухайлбал:

- “Нама сангади” хэмээхийг “Нэрийг үнэхээр өгүүлэхүй”
- “Амрида гүндали” хэмээхийг “Рашаан ойлох”
- “Базарсадва” хэмээхийг “Очирсадва”, “Очирт сэтгэлт”
- “Занасадва” хэмээхийг “Бэлгэ билгийн садва”, “Бэлгэ билгийн сэтгэлт” гэх мэт өгүүлбэр зүй, утга агуулгад нийцүүлэн дан санскритаар, зарим хэсэгт монголоор, зарим үед санскрит монгол хосолсон байдлаар орчуулж аль болох махчилсан нэг хэв загварт баригдахаас зайлсхийж уран тансаг сонгодог хэлбэрийг баримталсан нь үе үест нь таацуулж номын утга чанарыг ойлгуулахыг эрмэлзэхийн сацуу орчуулагч нарын мэдлэг чадварыг илэрхийлсэн хэрэг бизээ.

### **Хоёр. Утгын оноч үгийн баялагийг чухалчилсан**

Монгол Данжуурыг хөрвүүлэх явцад ажиглахад тухайн утга санааг илэрхийлэхдээ толгой холбох, илүү дутуу, чамин үг хэрэглэхээс татгалзаж утгыг нь ухах, санааг нь сэтгэх үг хэллэгүүдийг сонгон орчуулахыг чухалчилсан байна. Жишээ дурдвал:

Монгол Данжуур 1-р боть Магтаалын чуулган, "Ялангуяа хэтэрхий магтаал"-аас:

"Хамаг Түүнчлэн ирэгсдэд мөргөмү

Би бээр бус багшийг шүтээд

Ялж төгссөн чамаас аврал эрмүй

Тэр юуны тул хэмээвээс

Та нь гэм үгүй болоод эрдэм төгөлдөр"...

...Махадива хилэгнээд нэгэн сумаар

Гурван давхар балгасыг түлэв хэмээн алдаршив

Чиний бэлгэ билгийн их сумаар

Хилэнгийн чухам сэтгэлийг магад түлэв...

...Чамайг хэн ч айлгаж ядмуй

Хэнд ч үл хөнөөгчийн тул

Гагцхүү чи хэмээвээс мэсийг үл баримуй

Тиймийн тул амьтнуудаас хэтэрхий буй...

Энэ ном нь Хиндү шашинтан Тоозүндүвжай хэмээх уг номыг зохиогч өөрийн билиг оюунаар Бурхан багш болон түүний сургаалыг шинжлэх судалж үнэн зөв зам мөр болохыг таньж өөрийн багш нар, шашнаас татгалзан Бурхан багшийн сургаалыг баримтлан Бурханы шашинтан болсон тухай өгүүлдэг юм.

Эхний хэсэг эрдэм мэдлэгтэй зөв багшийг шүтэж үнэн зөв мөрийг эрхэмлэх тухай, удаах хэсэгт бусад өөр хоорондоо уур хилэн мэсээр тэмцэлдэж байхад төгс гэгээрсэн Бурхан багш билиг оюунаар уур, шунал тачаалыг уг мөргүй болтол арилгасан тухай өгүүлээд тиймээс та бусдаас хэтэрхий илүү гэсэн санааг орчуулагч учир шалтгаанд үндэслэнтөвч тодорхой эрэмбэ дараалалтай чадамгай илэрхийлсэн байна. Дээр дурдсан мөрүүдэд илүү дутуу үг нэгээхэн үгүй, "бус, болоод, чухам" гэсэн холбоос зөөлөн үгнүүдийг хэрэглэснээр утга санаа оночтой тодорхой илэрч байна. Ер нь Ганжуур Данжуурын орчуулгад "мөнхүү, чухам" гэх мэт утга тодотгох үгнүүд ихээр гардаг. Үргэлжлэл нь мөн энэ адил буй.

Монгол Данжуур төдийгүй Ганжуурын хувьд ч сонгодог монгол хэлний үг хэллэгээр нэн баян юм. Үүнээс дурдвал,

Түвд	Монгол
• Иф᠒-ffOP-ь	ноцог /тулга/
• үU-zhЭмь	үрэвгэл /үрүүл/
• өff¼-өffOP-ь	ариун сүрчил /23х/
• ¾Ю-GЭ-Mгһь	гинжир, барилдуулах
• z¼-᠒ь	чанар /тэмдэг/
• ᠒ЫG-!»ф¼-үе-qь	нүд жирвэгдэх /зурвас харах/
• үЛ-zБфЕь	амсуур, /балин/
• f-᠒³¼ь	танхай, үтэл, /эгэл/
• dфG-Gп-qь	томъёологчин /атгагч/ 44х
• өwф-zь	улирах /юүлэх/ 60х
• Z᠒E-EIO-᠋ФфP-zь	оюундаа амсах, бясалган сэтгэх
• 3тP-zь	архины бачим
• өhЭ-,пh	нийлдэх /хуран үйлдэх/
• T-Tфь	зурхиралдах /шуугих/

• zNYPEь	ханхалзах, босгох
• zBP- <sup>3</sup> / <sub>4</sub> ъь	харьдсан мөр, хошног
• Zп-z <sup>1</sup> / <sub>4</sub> ь	ухаглан, дотуурлан
• z3%опъE-ъь	эрэлхэх /хөөрөмших/
• GZЭG-ъь	байгаль /хулс/
• Gba <sup>3</sup> / <sub>4</sub> -мь	сүрчих, буригруулах /арцыг/
• ±ъ-Qъь	хувь, /татлал/
• өEЫ <sup>3</sup> / <sub>4</sub> -зъ	ойлогч /үелэх, эрчлэх/
• өEЫ <sup>3</sup> / <sub>4</sub> -зъ	туналзсан /эрчилсэн/
• ZъE- <sup>3</sup> / <sub>4</sub> пмь	жинлэн, цэгнэн сонсох
• ѠPфm-уфһь	гэсгээл /ил явдал/ хатуу үйл
• zdGE-ъь	сорих /шинжлэх, ажиглах/
• мь	сөль /цаботийн 443/
• үеG-ъь	хулгай гээг, /ар шил/
• z-Pмь	оронго /амьтан/
• Eh-hЭ-GEфһь	зорин эвдэх /басамжлах/
• өhЭm-q-ь	бахархах /зорих/
• ЗоP-Eпһь	үрэх /үзэгдэл түгэх/
• Vфъ-@Эмь	товтолгох /хулгай/
• »Ыh-hЭ-өфP-ь	тааламжит /сэтгэлд зохист/
• !D <sup>1</sup> / <sub>4</sub> -D-һь	наймаалж /мэлхий/
• @m-@ЫP-Тмь	шивэр шугуй /ой/
• һфGE-ъь	үтгэргэх /сэжиг/
• <sup>1</sup> / <sub>4</sub> Ы-3+пGEь	гургуул, өрөвтас
• Gф-өwP.ь	дэгжил, хутаг
• H!пm-hЭ-өEЫ <sup>3</sup> / <sub>4</sub> ь	дээшид өрмөглөн /босгох/
• FЫ <sup>3</sup> / <sub>4</sub> ь	манамж /сонжгууртай байх/
• Eфъ-ZЫ-ъпһь	түүдгэрэл /сэжиг, эргэлзээ/

Энэ мэт олон зуун үгийг дурдаж болох авч т бүхэнд сонирхуулах үүднээс цөөн үгийг дурдлаа.

Өгүүлж үл барах далай их ухааны сангаас өчүүхэн төдий нэгнийг чадан ядан өгүүллээ. Эцэст нь дүгнэн өгүүлбэл:

1. Ер хэн юу мэдэхийг хүснэм тэд Монгол Ганжуур, Данжуурыг сөхөж үзүүштэй юм.
2. Орчуулгын онол арга зүй, уламжлал, зарчмыг боловсронгуй болгоход өвөг дээдсийн маань өвлүүлсэн энэ их эх сурвалжууд нэгэн чиг болох нь дамжиггүй.
3. Монгол хэмээн бахархахын нууц тарни болсон сонгодог монгол хэлний далай их үгсийн санг хадгалалж буй Монгол Ганжуур Данжуурыг судалж ирээдүй хойчдоо өвлүүлэх нь зүй ёсны хэрэг болно.